



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар A/217

Бор-Өндөр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, 23 дугаар зүйлийн 23.4.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар зохион байгуулалт хийх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2025 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга

Газрын даамал

Гишүүд:

1-р багийн Засаг дарга

2- р багийн Засаг дарга

3- р багийн Засаг дарга

4- р багийн Засаг дарга

5- р багийн Засаг дарга

6- р багийн Засаг дарга

Байгаль хамгаалагч

Уулын баяжуулах үйлдвэрийн Ерөнхий эрчимзүйч

Уулын баяжуулах үйлдвэрийн Дулааны цехийн дарга

Бор-Өндөр сум дахь Онцгой байдлын хэлтсийн ГХУХБайцаагч

БЗӨБЦТС ТӨХК Говьсүмбэр салбар, Бор-Өндөр хэсгийн дарга


Бор-Өндөр хот тохижилт ОНӨТҮГ-ын дарга

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ний Бор-Өндөр салбарын ажилтан

2. 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын саналыг авч, газар дээр нь явж тодруулан судалж, Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөтэй уялдуулан, Газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим систем ашиглан боловсруулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хургуулэхийг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ